



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/128

Булган сум

Эзэмшил газрын зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2022 оны IX/19 дүгээр тогтоолоор баталсан “Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Ш.Мөнхбат (ГЮ73092976)-ын Булган сум 5 дугаар баг Анхдагчдын өргөн чөлөө 1 дүгээр гудамж 123 тоотод байршилтай 6308003381 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 2279 м² газрын зориулалтыг Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцны зориулалттай болгон өөрчилж, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилээр сунгасугай.

2. Ш.Мөнхбаттай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны А/116 дугаар захирамжийн Ш.Мөнхбаттай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР